



## БЛОКЧЕЙНИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Блокчейн /blockchain/ -ийг биткойн /bitcoin/ -ын суурь технологи болгон зохион бүтээсэн бөгөөд Тархмал Бүртгэлийн Технологи /Distributed Ledgers Technology/ (“ТБТ”) –ийн нэгэн төрөл юм. Харин ТБТ гэдэг нь өгөгдлийг хэд хэдэн өгөгдлийн сан (мөн бүртгэл /ledgers/ гэж нэрлэдэг) –д хадгалах буюу дамжуулах үйл явц ба өгөгдлийн сан тус бүрт яг ижил мэдээлэл бүртгэгдэж, зангилаа /nodes/ буюу компьютерийн серверийн тархмал сүлжээнд хамт байршин, хянагддаг байна. Мөн блокчейн нь криптограф /cryptography/ буюу шифрлэлт/encryption/ -ийн аргаар ажилладаг механизм бөгөөд математикийн тусгайлсан алгоритмыг ашиглан тасралтгүй нэмэгдэх өгөгдлийн бүтцийг бий болгон, баталгаажуулдаг байна. Өөрөөр хэлбэл, өмнөх мэдээллүүдийг устгалгүйгээр шинэ мэдээллүүдийг нэмж, “гүйлгээний блок / transaction block” –ын хэлхэг үүсгэдэг (үүнийг тархмал бүртгэл гэнэ)<sup>1</sup>.

Энэхүү технологи нь төвлөрсөн бус, нээлттэй, хамгаалалт сайтай, тархмал шинжтэй бөгөөд сүлжээний найдвартай байдал болон уламжлалт банкны системтэй харьцуулахад түргэн шуурхай (дэлгэрэнгүй мэдээллийг дараах сайтаас үзээрэй: <https://101blockchains.com/introduction-to-blockchain-features/#prettyPhoto>) байх тул ихэнх улс орнууд уг технологийг дэмждэг байна. Тухайлбал, Франц улс 2016 онд минибонд / minibons/ –ын бүртгэлийг блокчейн технологи ашиглан хийхийг зөвшөөрсөн тушаал гаргаж байжээ. Тус бондыг хүүтэй-нот гэж нэрлэдэг бөгөөд дамжуулан худалдах боломжгүй үнэт цаас юм. Бонд гаргагч нь зээлийн төлбөрийг тогтоосон хугацаанд төлөх үүрэг хүлээдэг байна. Цаашлаад, 2017 онд блокчейн технологийн бүртгэлийг ашиглаж болох санхүүгийн хэрэгслийн жагсаалтыг нэмэгдүүлсэн байна. Мөн Франц улсын худалдааны тухай хуульд уг технологийг санхүүгийн хэрэгслийг бүртгэх зохистой арга хэмээн тодорхойлсон байдаг байна<sup>2</sup>. Европын хувьд блокчейнд суурилсан гарын үсэг (хэн гүйлгээ хийсэн), цагийн бүртгэл (хэзээ гүйлгээ хийгдсэн), хүчин төгөлдөр байдал (гүйлгээг хэн баталгаажуулсан) болон баримт бичиг (гүйлгээ буюу гэрээтэй холбоотой мэдээлэл) –ийг хууль ёсоор хүлээн зөвшөөрснөөр блокчейнийн эрх зүйн байдлыг тогтоох урьдчилсан нөхцөл болно гэж үздэг бөгөөд эдгээр харилцааг Таних, Гэрчлэх болон Итгэмжлэгдсэн цахим үйлчилгээний журам (eIDAS) –аар зохицуулдаг байна<sup>3</sup>. Тухайлбал, уг журамд зааснаар цахим баримт бичиг нь цахим хэлбэртэй тул тэдгээрийн хүчин төгөлдөр байдлыг үгүйсгэж болохгүй гэж заасан байна. Энэ нь блокчейнд суурилсан бүртгэл буюу гэрээнд агуулагдаж буй мэдээллийн

<sup>1</sup> Cryptocurrencies and Blockchain, European Parliament, 2018

<sup>2</sup> pp12. Legal Regulatory Framework of Blockchains and smart contracts, The European Union Blockchain observatory and forum, 2019

<sup>3</sup> Мөн тэнд.

хууль ёсны байдлыг баталгаажуулдаг<sup>4</sup> байна (*дэлгэрэнгүй мэдээллийг дараах сайтаас үзээрэй [https://www.eublockchainforum.eu/sites/default/files/reports/report\\_legal\\_v1.0.pdf](https://www.eublockchainforum.eu/sites/default/files/reports/report_legal_v1.0.pdf)*).

Монгол улсын хувьд блокчейн технологийг хууль зүйн хүрээнд хүлээн зөвшөөрөөгүй хэдий ч Монгол улсын төлбөрийн системд бэлэн бус төлбөр тооцооны хэрэглээг дэмжих, шинэ дэвшилтэт төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээг нэвтрүүлэх, эрх зүйн орчинг бүрдүүлэх, олон улсын жишигт хүрсэн төлбөрийн системийн дэд бүтцийг хөгжүүлэх бодлого баримтлахаа илэрхийлсэн байдаг (МонголБанкнаас төлбөрийн системийн талаар баримтлах бодлого, 2012). 2017 онд батлагдсан Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд цахим мөнгө (*Монгол улсын цахим мөнгөний эрх зүйн зохицуулалтын талаар дараах сайтаас уншаарай <https://gratanet.com/publications/legal-summary-on-electronic-money-regulation-in-mongolia>*) –ийг Монгол Улсын мөнгөн тэмдэгт-төгрөгтэй адил үнэ цэнэ бүхий МонголБанкны зөвшөөрөлтэй гаргасан бэлэн бус төлбөрийн хэрэгсэл (5 дугаар зүйл) хэмээн тодорхойлсон байна. Монголбанк нь Төв Банкны тухай хуульд зааснаар мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах эрх бүхий цорын ганц субъект бөгөөд цахим мөнгийг Монголбанкны зөвшөөрөлтэй гаргаж болно гэсэн нь цахим мөнгөний хууль ёсны байдлыг илэрхийлж байна. Гэвч Монголбанкнаас зөвшөөрөлтэй гаргадаг (төвлөрсөн) шинжээрээ криптовалютаас (төвлөрсөн бус буюу гуравдагч этгээдийн оролцоогүй) ялгаатай юм. Монгол улс криптовалютын арилжааг эрх зүйн хүрээнд зөвшөөрөөгүй ч хязгаарласан эсхүл хориглосон зохицуулалт байхгүй байна. Харин үүний суурь технологи болох блокчейнийг цахим татварын систем, эд хөрөнгийн эрхийн бүртгэл, цахим төлбөрийн баримтын систем болон цахим гарын үсэг зэрэг төрийн болон банкны үйлчилгээнд ашиглаж байна. Түүнчлэн LendMN зэрэг санхүүгийн үйлчилгээний финтек компаниуд барьцаа хөрөнгө болон хүүгүйгээр зээл гаргах үйлчилгээ үзүүлэх нь нэмэгдэж байна. Гэсэн ч уг технологийн хэрэглээний эрх зүйн зохицуулалтыг хийгээгүй байна.

Дүгнэлт:

Монгол Улс блокчейн технологи болон түүнд суурилсан криптовалютын аль алиныг хуулийн хүрээнд хараахан зохицуулаагүй байна. Харин Монголбанкнаас бэлэн бус төлбөр тооцооны хэрэглээ болон шинэ дэвшилтэт төлбөрийн хэрэгсэл зэргийг дэмжих бодлого баримталдаг байна. Түүнчлэн, Монгол улс нь цахим мөнгө гаргах эрх зүйн орчныг бүрдүүлжээ. Блокчейн технологийг хуулийн хүрээнд зохицуулаагүй боловч татварын систем болон банкны үйлчилгээ зэрэг олон салбаруудад ашиглаж байна.

---

<sup>4</sup> pp12. Legal Regulatory Framework of Blockchains and smart contracts, The European Union Blockchain observatory and forum, 2019

Эх сурвалж:

1. Блокчейн - <https://en.wikipedia.org/wiki/Blockchain>
2. Блокчейн гэж юу вэ? - <https://unimedia.mn/457>;
3. Cryptocurrencies and Blockchain, European Parliament, 2018 - <https://www.europarl.europa.eu/cmsdata/150761/TAX3%20Study%20on%20cryptocurrencies%20and%20blockchain.pdf>;
4. Монголбанкнаас төлбөрийн системийн талаар баримтлах бодлого”, 2012 - [https://www.mongolbank.mn/documents/regulation/paymentsystem/20130102\\_payment\\_policy.pdf](https://www.mongolbank.mn/documents/regulation/paymentsystem/20130102_payment_policy.pdf);
5. Үндэсний төлбөрийн системийн тухай хууль - <https://www.legalinfo.mn/law/details/12668>;
6. Legal Regulatory Framework of Blockchains and smart contracts, The European Union Blockchain observatory and forum, 2019 - [https://www.eublockchainforum.eu/sites/default/files/reports/report\\_legal\\_v1.0.pdf](https://www.eublockchainforum.eu/sites/default/files/reports/report_legal_v1.0.pdf);
7. Basic features of Blockchain Technology - <https://101blockchains.com/introduction-to-blockchain-features/#prettyPhoto>.

***Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл GRATA International Хуулийн Фирмийн партнер В.Болормаа болон хуульч Т.Буянжаргалтай [bvolodya@gratanet.com](mailto:bvolodya@gratanet.com), [btungalag@gratanet.com](mailto:btungalag@gratanet.com) эсхүл +976 70155031 утсаар холбогдоорой.***